



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

“ЦАГААНШОНХОР” ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Т.БАТБОЛД ТАНАА

2013.03.20 № ҮН-САН/2013/67/СТЖ-ТӨЛ 01/43

Хувь хүний орлогын албан татварыг
нөхөн төлүүлэх тухай.

“Цагаан шонхор” ТӨААТҮГ-ын 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн Санхүүгийн тайланд аудит хийх явцад бараа ажил үйлчилгээ худалдан авсан 9143.0 мянган төгрөгнөөс хувь хүний орлогын албан татвар 914.3 мянган төгрөгийг төсөвт төлөөгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27.1.4-д “энэ хуулийн 12-р зүйл, 13.1.15, 14.1.2, 14.1.3-т заасан орлогод энэ хуулийн 23.1-д заасан хувиар тооцон улирал тутам албан татвар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор төлөх” тухай заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын”-ын 2.1.1-д “Төлбөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн болон төвлөрүүлээгүй алдаа, зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тавина” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувь хүний орлогын албан татварт төлбөл зохих 914.3 мянган төгрөгийг ҮАГ-ын Төрийн сан банкин дахь улсын төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2013 оны 5 дугаар сарын 01-ний дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж, 2013 оны 5 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг “Цагааншонхор” ТӨААТҮГ-ын захирал Т.Батболд, ерөнхий нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа нарт хариуцуулав.

ТОГТООСОН: АКТ

Үндэсний аудитын газрын
Ахлах аудитор Д.Данбилэг

“Си Эс Ай Аудит” ХХК-ны захирал

М.Сэвжидмаа

ЗӨВШӨӨРСӨН:

“Цагааншонхор” ТӨААТҮГ-ын захирал
Т.Батболд

ерөнхий нягтлан бодогч

Ц.Цэнгэлмаа



070133